



УР ЧАДВАРЫН НЭМЭГДЭЛ ОЛГОХ

1. Ажилтны ур чадварын нэмэгдлийг батлагдсан хүснэгтийн дагуу ажилтан тус бүрээр дүгнэн доорх хувиар олгоно.

2. Хэлтсийн дарга нарын ур чадварын нэмэгдлийг үйлдвэрийн газрын дарга 25 хүртэлх хувиар;

3. Захиргаа, инженер техникийн ажилчдын ур чадварын нэмэгдлийг тухайн хэлтсийн дарга 25 хүртэлх хувиар;

4. Урсгал засварын засварчдын ур чадварын нэмэгдлийг тухайн хэлтсийн засварын инженер тодорхойлж, хэлтсийн дарга баталгаажуулж 25 хүртэлх хувиар;

5. Автобусны жолоочийн ур чадварын нэмэгдлийг тооцохдоо шугам цагийн даалгаврыг 100 хувь буюу түүнээс дээш хувиар биелүүлсэн, сахилгын шийтгэлгүй байх тохиолдолд тухайн хэсгийн хэсгийн дарга тодорхойлж, ахлах инженер хянаж, хэлтсийн даргын баталсан тодорхойлолтыг үндэслэн дараах байдлаар тооцно

- Их багтаамжийн дизель хөдөлгүүртэй автобус- 25 хүртэлх хувь
- Дунд багтаамжийн автобус- 25 хүртэлх хувь

6. Автобусны жолооч нь ажилласан шугам цагийнхаа 50 хувиас дээш хувьд нь ээлжтэй ажилласан, тухайн сарын шугам цагийн даалгаврыг 100 буюу түүнээс дээш хувиар биелүүлсэн бол ажилласан шугам цагаас 3 хувиар тооцож олгоно.

7. Ээлжтэй ажиллах гэдэг ойлголтыг тухайн өдрийн шугамд ажиллаж байгаа жолооч нар ээлж солилт хийж ажиллах ба нэг жолоочийн шугамд ажилласан цаг 9 цагаас хэтрэхгүй байвал ээлжтэй, 9 цагаас хэтрүүлж ажиллавал уртаар явсан гэж ойлгоно.

8. Ур чадварын нэмэгдлийг ажилтан тухайн сард ажиллавал зохих хоногийн 70 хувь буюу түүнээс дээш хоног ажилласан ажилтанд үндсэн цалингаас тооцож 25 хүртэл хувиар тооцож олгоно.

9. Хэлтсийн дарга нь тухайн ажилтны ажлыг шалгуур үзүүлэлтийн дагуу оноогоор дүгнэн тухайн сарын 23-нд тодорхойлсныг, санхүү, бүртгэлийн хэлтэс нэгтгэн, нэмэгдэл цалингийн хувийг газрын даргаар батлуулан сарын сүүл цалинтай хамт олгоно.

10.Тухайн сард сахилгын арга хэмжээ авагдсан, ажил олгогчийн санаачилгаар хөдөлмөрийн гэрээ цуцлагдсан ажилтанд ур чадварын нэмэгдэл олгохгүй.

Шалгуур үзүүлэлт

Шалгуур	Нийт хувь	
	Авах хувь	Авсан хувь
Хөдөлмөрийн гэрээ болон ажлын байрны тодорхойлолтоор гүйцэтгэсэн ажил	5	
Мэргэжлийн ур чадвар, ёс зүй	5	
Багаар ажиллах ур чадвар	5	
Олон нийтийн ажил, үүрэг даалгаврын биелэлт	5	
Ажлын цаг ашиглалт	5	
Хөдөлмөрийн гэрээ болон ажлын байрны тодорхойлолтоор гүйцэтгэсэн ажил	5	
Нийт хувь		